

Хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад хийсэн шалгалтын талаарх танилцуулга

Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч 46 байгууллагаас 2014-2015 онд хийсэн хяналт шалгалтын эрсдлийн үнэлгээг үндэслэн 2016 онд “ББ-Од” ХХК, “Арвин шар зам” хоршоо, “АйС ВН”, “Дарьганга өртөө” хоршоо, “Дэлгэрэх хүнс” ХХК, “Баянхонгор тээвэрчин” хоршоо, “Аяны зам Алтай” ХХК, “Аж мянган” ХХК, “Эрдэм транс” ХХК зэрэг 9 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг шалгаж, МХЕГ-ын даргын баталсан 5.21 кодтой “Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагыг шалгах хяналтын хуудас”-ын дагуу эрсдэлийг тооцож, улсын байцаагчийн 9 албан шаардлага хүргүүлсэн ба **дотоод хяналт хэрэгжүүлж ажиллаагүй** “Эрдэм транс” ХХК-д мөн зөрчил гаргасан 7 жолоочид холбогдох хуулийн дагуу 1'110'000 төгрөгийн торгууль оногдуулсан.

Мөн МХЕГ-тай хамтран ажиллах төлөвлөгөөг үндэслэн МХЕГ-ын ДБХГ-ын баталсан “Зөвлөн туслах үйлчилгээний хөтөлбөр”-ийн дагуу хот хоорондын нийтийн тээвэр эрхлэгч “Хийморийн зам” ХХК, “Эрдэм транс” ХХК, “Юнайтэд Бра” хоршоонд 2016.10.04-07-ны өдрүүдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, улсын байцаагчийн 2016.10.13-ны 06/097/54, 06/097/55, 06/097/56 дугаар бүхий эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг дээрх байгууллагуудад хүргүүлсэн.

Стандартын шаардлага хангаагүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх ажлын хүрээнд хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч 40 аж ахуйн нэгж байгууллагын 213 насжилт хэтэрсэн тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн үйл ажиллагааг зогсоосон.